



**МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ**

14251 Улаанбаатар хот,  
Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө 11,  
Утас: (976) 51-267168, Факс: (976) 11-312315,  
E-mail: info@mrtд.gov.mn, http://www.mrtд.gov.mn

2022.05.03 № 03/2014  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Г САНГИЙН ЯАМНЫ ТӨРИЙН САНГИЙН  
ГАЗАРТ**

Зам, тээврийн хөгжлийн яамны баталгаат хугацааны барьцаа хөрөнгийн 100900028350 тоот харилцах дансанд байршиж байгаа үлдэгдлээс хавсралтад заасан “Жавхлан харгуй” ХХК-д гэрээний дагуу олгох 48,575,209.0 (дөчин найман сая таван зуун далан таван мянга хоёр зуун ес) төгрөгийн эрхийг зохих журмын дагуу нээж өгнө үү.

Хавсралт.....<sup>13</sup> хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА

С.БАТБОЛД



080001576

Зам, тээврийн хөгжлийн яамны баталгаат хугацааны барьцаа хөрөнгийн 100900028350 тоот харилцах данснаас барьцаа хөрөнгө олгох жагсаалт

2022.04.28

/төгрөгөөр/

№	Төсөл, арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч компани	2022 оны эхний үлдэгдэл	2022 онд нэмэгдсэн орлого	2022 онд олгосон дүн	Одоо олгох дүн	Үлдэгдэл	Гэрээний заалт	Шийдвэр
	Эрх нээлгэх нийт дүн		48,575,209.00	0.00	0.00	48,575,209.00	0.00		
1	Аймгийн төвийн авто замын дуусгалт, 5.78 км /Орхон, Баян-Өндөр сум/ ажил	Жавхлан харгуй ХХК	48,575,209.00			48,575,209.00	0.00	Тусгай нөхцлийн 32.0. Чанарын баталгаат хугацаа: ашиглалтад хүлээлгэн өгснөөс хойш 3 жил байна.	Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын 2016.12.28-ны өдрийн № 07/22/16 дугаартай акт Орхон аймгийн Эрдэнэт хотын захирагчийн албаны даргын 2022.04.19-ний өдрийн 98 тоот албан бичиг

Хянасан:

Бодлого, төлөвлөлтийн газрын дарга



Д.Гэрэлням

Бодлого, төлөвлөлтийн газрын СХОХ-ийн дарга

Ч.Ренчиндамба

Боловсруулсан:

Бодлого, төлөвлөлтийн газрын СХОХ-ийн шинжээч



Н.Баярсайхан



## ЭРДЭНЭТ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЛБА

61033, Орхон аймаг Баян-Өндөр сум Уртбулаг баг  
Ханддоржийн гудамж, Утас/Факс: 70358012  
Цахим шуудан: HZA@erdenet.mn

2022.04.19 № 98  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### “ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ”-НД

“Жавхлан харгуй” ХХК нь 2015 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 160 тоот гэрээний дагуу Орхон аймгийн Баян-Өндөр сумын “Говил багийн 4.117км авто замын засвар шинэчлэлтийн ажил”-ыг зураг төслийн дагуу гэрээт хугацаанд хийж гүйцэтгэн байнгын ашиглалтанд хүлээлгэн өгсөн.


Тус компаниас ирүүлсэн албан тоотын дагуу газар дээр нь ашиглагч, зохиогч, хяналтын инженерийг байлцуулан үзлэг хийхэд одоогийн байдлаар гарсан гэмтэл, эвдрэлгүй ашиглалтын шаардлага хангаж байна.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ  С.ГАНЦОГ



## НЭХЭМЖЛЭХ № .19.

Нэхэмжлэгч: \_\_\_\_\_ Төлөгч: \_\_\_\_\_  
 Байгууллагын нэр: Жовмон харгуй ХХК Байгууллагын нэр: ЗТХЯОм  
 Хаяг: \_\_\_\_\_ Хаяг: \_\_\_\_\_  
 Утас: Факс: 99355205  
 Э шуудан \_\_\_\_\_ Гэрээний № №160  
 Банкны нэр Төрийн Банк  
 Банкны дансны дугаар 4025109080 Нэхэмжилсэн огноо 2022.04.26  
 Регистрийн №: 5815177 Төлбөр хийх хугацаа \_\_\_\_\_

№	Гүйлгээний утга	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
	<u>Барьцааны 5%</u>			<u>48575209</u>
	<u>(Товч болт барьцааг 4.117км хатуу хуучилттай (хөвдөр)</u>			
			Дүн	
			НӨАТ	
			Нийт дүн	<u>48575209</u>

Мөнгөний дүн дэвчин нөхсөн авч төлөн зүүн  
дамон төлөн мөнгө (үсгээр) хөр зүүн өсөн төрөлж болно  
 Дарга \_\_\_\_\_ /  
 Хүлээн авсан \_\_\_\_\_ /  
 Нягтлан бодогч  /



**ЗАХИАЛАГЧ:**  
ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

БАТЛАВ:

**ГҮЙЦЭТГЭГЧ:**  
“ЖАВХЛАН-ХАРГУЙ” ХХК-ийн  
ЗАХИРАЛ

Д.МӨНХ-ОЧИР

**“АЙМГИЙН ТӨВИЙН АВТО ЗАМЫН ДУУСГАЛТ 5.78 КМ /ОРХОН, БАЯН-ӨНДӨР СУМ/”-ЫН БАРИЛГЫН АЖЛЫН ҮЛДЭГДЭЛ БОЛОХ ЭРДЭНЭТ ХОТЫН ГОВИЛ БАГТ БАРИГДАХ 4.117 КМ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫН БАРИЛГЫН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

2015 оны 07 дугаар  
сарын 31-ны өдөр

№ 160

Улаанбаатар хот

Нэг талаас Зам, тээврийн яам /цаашид захиалагч гэх/, нөгөө талаас “Жавхлан-Харгуй” ХХК /цаашид гүйцэтгэгч гэх/ дараах зүйлийг харилцан тохиролцож энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав

**Нэг. Ерөнхий зүйл**

- 1 Монгол Улсын Иргэний, Барилгын болон бусад хууль, тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга, зам, байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулах, замын зураг төсөл боловсруулахтай холбогдсон захиалагч гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- 2 Захиалагч нь “Аймгийн төврийн авто замын дуусгалт 5.78 км /Орхон, Баян-Өндөр сум/”-ын барилгын ажлын үлдэгдэл болох Эрдэнэт хотын говил багт баригдах 4.117 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг (цаашид “ажил” гэх) 971,834,282.00 /Есөн зуун далан нэгэн сая найман зуун гучин дөрвөн мянга хоёр зуун наян хоёр/ төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн үнийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
- 3 Гэрээний нийт дүн: 971,834,282.00 төгрөг. Үүнээс:
- 4 Гүйцэтгэгч нь ажлыг 2015 оны 08 дугаар сарын 10 -ний өдөр эхэлж, 2015 оны 09 дугаар сарын 20-ийн дотор захиалагчид хүлээлгэн өгнө.
- 5 Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно. /цаашид гэрээний бичиг баримт гэх/. Үүнд:
  - Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
  - Гэрээний тусгай нөхцөл;
  - Гэрээний ерөнхий нөхцөл;
  - Ажлын зураг;
  - Техникийн тодорхойлолт;
  - Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь;
  - Санхүүжилтийн хуваарь;
  - Ажил гүйцэтгэх хуваарь.
  - Гүйцэтгэлийн баталгаа
  - Бусад шаардлагатай баримт бичиг;

- 6 Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд зөрчигдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.
- 7 Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
- 8 Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн гэрээнд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
- 9 Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
- 10 Ажлыг чанарын баталгаа 3 жил байх бөгөөд энэ хугацаанд эвдрэл, гэмтэл гарсан тохиолдолд гүйцэтгэгч тал өөрийн 100%-ийн хөрөнгөөр хохирлыг барагдуулна.


### Хоёр. Маргааныг шийдвэрлэх

Талууд энэхүү гэрээтэй холбогдон үүссэн маргааныг харилцан ойлголцож, шийдвэрлэж чадахгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт орвол хоёр тал албан бичгээр зөвшилцөнө.

### Талууд:

#### ЗАХИАЛАГЧИЙН ТАЛААС :

Зам, тээврийн яамны Авто замын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

.....  
 Д.Доржханд

Зам, тээврийн яамны Стратегийн бодлого, төлөвлөлт, хамтын ажиллагааны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

.....  
 С.Адъяасүрэн

Зам, тээврийн яамны Стратегийн бодлого, төлөвлөлт, хамтын ажиллагааны газрын Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга

.....  
 З.Цэрэнчимэг


#### ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТАЛААС:

"Жавхлан Харгуй"ХХК-ийн инженер

.....  
 Д.Болд

Ерөнхий ня-бо

.....  
 Н.Лхагвасүрэн



## ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

### А. ЕРӨНХИЙ ЗААЛТ

#### 1. Нэр томъёо

1.1. Тодорхойлсон нэр томъёог тод үсгээр бичив.

**Үе шатны ажлын хуваарь /ажлын тоо хэмжээ/** гэж гүйцэтгэгчээс үе шатны ажил/ажлын тоо хэмжээ/-ын үнийг тусгаж тендерийн хамт ирүүлсэн хуваарийг хэлнэ.

**Нөхөн төлбөр хийх нөхцөл** гэж энэхүү ГЕН-ийн 41 дүгээр зүйлд тодорхойлсон нөхцөлүүдийг хэлнэ.

**Ажил дууссан өдөр** гэж ГЕН-ийн 52.1-д заасны дагуу ажил дууссаныг төслийн менежер гэрчилсэн өдрийг хэлнэ.

**Гэрээ** гэж захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан ажил гүйцэтгэх, дуусгах, засвар үйлчилгээ явуулах гэрээг хэлнэ. Гэрээ нь гэрээний маягтын 5 дугаар зүйлд дурдсан баримт бичгээс бүрдэнэ.

**Гүйцэтгэгч** гэж захиалагчийн хүлээн зөвшөөрсөн тендерийг ирүүлсэн этгээдийг хэлнэ.

**Тендер** гэж захиалагчийн тавьсан нөхцөл, болзлын дагуу гүйцэтгэгчийн бэлтгэж ирүүлсэн иж бүрдэл баримт бичгийг хэлнэ.

**Гэрээний үнэ** гэж гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэлд дурдсан, гэрээний заалтын дагуу цаашид тохируулж болох үнийг хэлнэ.

**Хоног** гэж хуанлийн хоногийг, **сар** гэж хуанлийн сарыг тус тус хэлнэ.

**Ажил-өдөр** гэж ажлын төлбөр нь гүйцэтгэгчийн ажиллах хүч болон тоног төхөөрөмжийн ажилласан хугацаанд (хүн-цаг болон машин-цаг) үндэслэн хийгдэх зардлыг хэлнэ.

**Зөрчил, гологдол** гэж зураг төсөл, техникийн тодорхойлолтыг зөрчсөн, чанарын гологдол гаргасан буюу ажлын гэрээнд заасны дагуу хийгдээгүй ажлыг хэлнэ.

**Зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл** гэж гүйцэтгэгч зөрчил, гологдлыг арилгасныг үндэслэн төслийн менежерийн гаргасан баталгааг хэлнэ.

**Чанарын баталгаат хугацаа** гэж гэрээний тусгай нөхцөлд заасан, ажил дууссан өдрөөс эхлэн тоологдох хугацааг хэлнэ. Энэ хугацаанд илэрсэн зөрчил, гологдлыг гүйцэтгэгч арилгах үүрэгтэй.


**Зураг** гэж батлагдсан зураг төсөл болон түүнтэй холбоотойгоор төслийн менежерийн гаргасан, баталсан тооцоо, бусад мэдээллийг хэлнэ.

**Захиалагч** гэж ажил хийлгэхээр гүйцэтгэгчийг хөлслөн ажиллуулж буй этгээдийг хэлнэ.

**Тоног төхөөрөмж** гэж ажил гүйцэтгэх зорилгоор ажлын талбайд түр хугацаагаар авчирсан гүйцэтгэгчийн машин

2015.06.06

- 44.2. Хэрэв индексийн дүн нь түүнийг тооцоонд ашигласнаас хойш өөрчлөгдсөн бол тооцоог залруулж, дараагийн төлбөрийн мэдэгдэлд энэ дагуу тохируулга хийнэ. Индексийн дүнг тооцохдоо үнийн хэлбэлзлийн улмаас гарсан зардлын бүх өөрчлөлтийг энд харгалзсан гэж үзнэ.
- 45. Барьцаа хөрөнгө**
- 45.1. Захиалагч нь гүйцэтгэгчид төлөх гүйцэтгэлийн төлбөр бүрээс гэрээний тусгай нөхцөлд заасан тодорхой хувийг суутгаж үлдээнэ.
- 45.2. Барилгын ажлын чанарын баталгаат хугацаа дууссаны дараа чанарын баталгаат хугацаанд гарсан бүх зөрчил, гологдлыг гүйцэтгэгч арилгасан тухай төслийн менежерийн мэдэгдлийг захиалагч баталгаажуулснаар барьцаа хөрөнгийг гүйцэтгэгчид олгоно.
- 45.3. Ажлыг бүхэлд нь дуусгамагц гүйцэтгэгч захиалагчид банкны батлан даалт гаргаж өгснөөр уг батлан даалтад заасан дүнтэй тэнцүү хэмжээний төлбөрийг чанарын баталгаат хугацааны барьцаа хөрөнгөөс урьдчилж авч болно.
- 46. Алданги**
- 46.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.
- 47. Урамшуулал**
- 47.1. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс өмнө дууссан хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр гүйцэтгэгчид урамшуулал олгоно. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр болоогүй боловч гүйцэтгэгч ажлыг бүрэн дуусгасан бол төслийн менежер энэ тухай мэдэгдэл гаргана.
- 48. Урьдчилгаа төлбөр**
- 48.1. Захиалагч гэрээний тусгай нөхцөлд заасан дүнтэй урьдчилгаа төлбөрийг уг өгөгдөлд заасан хугацаанд гүйцэтгэгчид төлнө. Урьдчилгаа төлбөрийн дүнтэй тэнцүү, ижил валютаар илэрхийлэгдсэн банкны батлан даалт буюу үл маргах нөхцөлтэйгээр банкнаас гаргасан урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслэн энэхүү төлбөрийг хийнэ. Гэхдээ энэ батлан даалтын дүн нь гүйцэтгэгчийн эргэж төлөгдсөн урьдчилгаа төлбөрийн хэмжээгээр буурч байна. Урьдчилгаа төлбөрт хүү ногдуулахгүй.
- 48.2. Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийг зөвхөн гэрээг гүйцэтгэхэд шаардагдах тоног төхөөрөмж, байгууламж, материал болон ажил эхлүүлэхтэй холбогдсон зардалд зарцуулна. Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийг энэ зорилгод ашигласныг нотлохын тулд нэхэмжлэх болон бусад баримтын хувийг төслийн менежерт ирүүлнэ.
- 48.3. Урьдчилгаа төлбөр нь хийгдсэн үе шатны ажлын дагуу гүйцэтгэгчид төлөх төлбөрийн хэмжээнээс холбогдох дүнг суутгах замаар эргэж төлөгдөнө. Хийгдсэн ажлын үнэ, өөрчлөлт, үнийн тохируулга, нөхөн төлбөр, урамшуулал болон алдангийн дүнг тооцохдоо урьдчилгаа төлбөр, эсхүл түүнийг эргэж төлөгдсөн байдлыг харгалзахгүй.







## ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

Дор дурдсан баримт бичиг нь гэрээний хэсэг болно:

- 55.0 Ажлын хуваарь: Гэрээнд гарын үсэг зурснаас хойш 14 хоногийн дотор ажлын хуваарь гаргаж батлуулна.
- 8.0 Бусад гүйцэтгэгчдийн хуваарь
- 9.0 Голлох мэргэжилтний хуваарь
- 14.0 Ажлын талбайн судалгааны тайлан
- 1.1 Захиалагч: **Зам, тээврийн яам**
- 1.1 Төслийн менежер: **Гэрээ байгуулагдсанаас хойш Захиалагч төслийн менежерийг томилно.**
- 1.1 Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар нь: **“Аймгийн төврийн авто замын дуусгалт 5.78 км /Орхон, Баян-Өндөр сум/”-ын барилгын ажлын үлдэгдэл болох Эрдэнэт хотын говил багт баригдах 4.117 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг гүйцэтгэх гэрээ**
- 1.1 Ажил эхлэх өдөр: **Гэрээ байгуулсан өдрөөс 14 хоногын дотор.**
- 1.1 Ажлын талбай нь Орхон аймагт ба ажлын зурагт зааснаар тодорхойлогдсон болно.
- 3.0 Гэрээний баримт бичгүүд нь **Монгол** хэл дээр байна.
- 3.0 Гэрээнд Монгол Улсын хуулийг хэрэглэнэ.
- 13.0 Даатгалд зайлшгүй хамруулах зүйл, даатгалын дүнгийн доод хэмжээ нь: **Гүйцэтгэгч бүрэн хариуцна.**
- 17, 26 Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр: **2015 оны 04 дугаар сарын 20-нд гэрээт бүх ажлыг дуусгана.** төгрөгөөр
- 21.0 Ажлын талбайг ашиглуулж эхлэх өдөр **Гэрээ хүчин төгөлдөр болсноос 14 хоногийн дотор**
- 25.0 Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
- 25.0 Ажлын хөтөлбөрийг 30 хоног тутам тодотгоно.
- 25.0 Тодотгосон ажлын хөтөлбөрийг хугацаанд нь ирүүлээгүй тохиолдолд суутгах үнийн дүн нь **1,000,000 /нэг сая/ төгрөг** байна.
- 32.0 Чанарын баталгаат хугацаа: **ашиглалтад хүлээлгэж өгснөөс хойш 3 жил байна**
- 39.0 Төлбөрийн мэдэгдэлд НӨАТ, Гааль, хяналтын зардал болон цалингаас



- тооцогддог бусад дайвар зардлуудыг тусгасан дүнгээр гүйцэтгэл болгон дээр гаргана.
- 39.0 Гүйцэтгэлийн тайланг санхүүжилтийн хуваарийн дагуу Захиалагчид гаргаж өгөх бөгөөд урьдчилгаа төлбөр авсан тохиолдолд урьдчилгаа төлбөрийг хасаж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 40.0 Төлбөр хийх хугацаа нь төлбөрийн мэдэгдэл гаргасан өдрөөс хойш 30 хоног байна.
- 44.0 Гэрээний ерөнхий нөхцөлийн 44 дүгээр зүйлийн дагуу гэрээнд үнийн тохируулга хийх: **Тохируулга хийхгүй**
- 45.0 Барьцаа хөрөнгийн хувь нь 5 хувь байна.  
**Чанарын баталгаат хугацаа дууссаны дараа тэр хугацаанд гаргасан бүх зөрчил, гологдлыг гүйцэтгэгч арилгасан тухай төслийн менежерийн мэдэгдлийг захиалагч баталгаажуулснаар чанарын баталгаанд гүйцэтгэгчээс гаргаж өгсөн банкны батлан даалтыг чөлөөлнө.**
- 46.0 Алданги ногдуулах хэмжээ: Хугацаа хэтэрсэн хоног дутамд гүйцэтгээгүй ажлын үнийн дүнгийн 0,25 хувь байна.
- 46.0 Нийт ажилд ногдуулах алдангийн хэмжээ нь **гэрээний үнийн 10 хувиас хэтрэхгүй бөгөөд хэтэрсэн тохиолдолд гэрээг цуцлах арга хэмжээ авна.**
- 47.0 Урамшуулал олгох хэмжээ нь хоногт гэрээний үнийн 0 хувь байна.
- 47.0 Нийт ажилд олгох урамшууллын дээд хэмжээ нь гэрээний үнийн 0 хувь байна.
- 48.0 Гүйцэтгэгчээс ирүүлсэн хүсэлтийг харгалзан Төндөрийн баримт бичгийн 7 дугаар зүйлд заасан маягтын дагуу гаргасан Монгол Улсад хүлээн зөвшөөрөгдсөн арилжааны банкнаас ирүүлсэн урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслэн тухайн жилд санхүүжүүлэх үнийн дүнгийн 30 хүртэлх хувийн урьдчилгаа төлбөрийг гүйцэтгэгчид олгож болно.
- 49.0 Гүйцэтгэлийн баталгаа нь гэрээний үнийн 5 хувьтай тэнцүү дүнтэй байна. Гүйцэтгэлийн баталгаа нь төндөрийн баримт бичгийн 7 дугаар бүлэгт заасан маягтын дагуу байна.
- 58.0 **Гүйцэтгэгчийн буруугаас шалтгаалж гэрээ цуцлагдсан бол хийгдсэн ажлыг захиалагчийн өмч гэж үзнэ.**



БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАНД

ОРУУЛАХ КОМИССЫН АКТ

2016 оны 12 сарын 28-ны өдөр

Дугаар...

08/28/16

Эрдэнэт хот

НЭГ

- 1.1 Барилга байгууламжийн нэр, байршил, хүчин чадал  
Орхон аймгийн Баян-Өндөр сум, Говил баг 4.117км хатуу хучилттай авто зам засвар, шинэчлэлтийн ажил
- 1.2 Захиалагч аж ахуйн нэгж, байгууллага (Зөвлөх үйлчилгээ эрхлэгч)  
ЗТХЯам
- 1.3 Ашиглагч аж ахуйн нэгж, байгууллага  
ХТГазар
- 1.4 Ерөнхий болон туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллага  
"Жавхлан Харгуй" ХХК
- 1.5 Зураг төсөл боловсруулсан аж ахуйн нэгж, байгууллага  
"Мон АЗ" ХХК Шифр: 08/10
- 1.6 МУ-ын Засгийн газрын 2012 оны 151-р тогтоол шийдвэрээр зохион байгуулсан 7-н хүний бүрэлдэхүүнтэй "Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комисс" нь уг барилга байгууламжийг ашиглалтанд оруулахад бэлэн болсон тухай Захиалагч байгууллагын 2016 оны 12-р сарын 28-ны өдрийн № А22 тоот мэдэгдлийн дагуу 2016 оны 12 сарын 28-ны өдөрт багтаан ажлын чанар, холбогдох акт, баримтуудтай танилцаад газар дээр нь шалган үзэв.
- 1.7 Энэхүү барилга байгууламжийг шифр: 08/10 дугаартай зураг төслөөр 2015 оны 08 сарын 10 -наар барьж эхлэсэн бөгөөд 2016 оны 10 сарын 30-ны өдөр барьж дуусгасан байна.

ХОЁР.

- 2.1 Энэхүү Орхон аймгийн Баян-Өндөр сум, Говил багийн авто зам засвар, шинэчлэлтийн ажил ажлын холбогдох акт, баримтуудыг шалгаад комиссоос  
ШИЙДВЭРЛЭСЭН НЬ: Ашиглалтанд хүлээн авахаар шийдвэрлэв.
- 2.2 Энэхүү Орхон аймгийн Баян-Өндөр сум, Говил багийн авто зам засвар, шинэчлэлтийн ажлыг ашиглахад шаардлага хангана гэж үзээд захиалагч (ашиглагч) байгууллага болох ХТГазрын мэдэлд 2016 оны 12 сарын 28 -ны өдрөөс ашиглалтад (үйлдвэрлэл, үйлчилгээ, оршин суух зэрэг) оруулахыг зөвшөөрөв.

Комиссоос даалгах нь:

Гүйцэтгэгч байгууллагад:

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын акт, холбогдох баримтуудын эх хувийг өрхнөт, үлдэх хувийг ашиглагч байгууллагад 7 хоногийн дотор багтаан шилжүүлэх.

Захиалагч (ашиглагч) байгууллагад:

А) Барилга байгууламжийн ашиглалтын дүрмийн дагуу барилга байгууламжийн хувийн хэрэгт баяжилт хийж байх

Б) Барилга ашиглалтын дүрмийн дагуу барилгыг хэвийн ашиглаж, засвар арчлалтыг тогтоосон хугацаанд тогтмол хийж байх

2.1 Комиссын акт 3 хуудас, хурлын тэмдэглэл 6 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаварын биелэлтийн жагсаалт ... хуудас материал, барилга байгууламжийн бичиг, баримтын жагсаалтыг хавсаргав.

Тухайн барилга байгууламжийн нэрийг бичнэ.

Орхон аймгийн Баян-Өндөр сум, Говил баг 4,117км авто зам засвар, шинэчлэлтийн ажил

КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН:

Комиссын дарга:

Т.Гомбосүрэн



Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч:

Нарийн бичгийн дарга:

У.Эрдэнэбаатар



Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Зам, тээврийн хяналтын хэлтэсийн мэргэжилтэн:

Гишүүд:

Х.Хуандаг












Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Зам, тээврийн хяналтын хэлтэсийн мэргэжилтэн /Б.Насантогтохыг орлон/

О.Лхагвасүрэн



Зам, тээврийн хөгжлийн төвийн Замын хяналтын хэлтэсийн мэргэжилтэн

Орхон аймгийн Баян-Өндөр сум, Говил баг 4,117км авто зам засвар,  
шинэчлэлтийн ажил

- |                 |   |   |
|-----------------|---|---|
| Г. Буянхүү      |    | Орхон аймгийн Газрын харилцаа, барилга хот<br>байгуулалтын газрын мэргэжилтэн<br>/Зөвшилцсөнөөр/            |
| П. Одончимэг    |    | Орхон аймгийн Баян-Өндөр сумын Байгаль<br>орчин аялал жуучлалын газрын ахлах<br>мэргэжилтэн /зөвшилцсөнөөр/ |
| М. Баттулга     |    | Орхон аймгийн замын цагдаагийн тасгийн<br>хошууч  |
| Б. Оюунбаяр     |    | Хот тохижуулах газрын дарга   |
| Г. Нанжид       |    | Хот тохижуулах газрын инженер   |
| Ш. Ононгал      |    | "Онцгой байдлын газар"-аас гамшгаас<br>хамгаалах улсын хяналтын байцаагч                                    |
| Г. Эрдэнэбаатар |   | "Мон-Аз" ХХК-ний зургийн инженер /зураг<br>төслийн байгууллагын төлөөлөл/                                   |
| Д. Мөнх-Очир    |  | "Жавхлан харгуй" ХХК-ний захирал<br>/Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөгч/                                     |
| Д. Дэлгэрмаа    |  | Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн<br>захиргааны удирдлагын газрын Архивын<br>эрхлэгч                      |